



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/107

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дэх заалт, 14.4 дэх хэсэг, Засгийн газрын 2026 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэр, Засгийн газрын 2021 оны 5 дугаар тогтоолын 3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/49 дүгээр захирамж, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын аварга малчин, аймгийн хошой аварга, аварга малчин, хадланч, тариаланчид болон Монголын үндэсний олон нийтийн телевизээс зарласан алтан төлийн эзэд болсон малчдыг шагнаж урамшуулахад шаардагдах 8,959,400 (найман сая есөн зуун тавин есөн мянга дөрвөн зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөтийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

